

ДЭВШИЛ МАНДАЛ ХК

Дундговь аймаг,
Сайнцагаан сум

Утас: 99300500

99095960

devshilmandal@outlook.com

2026-04-30

Дугаар 02/19

"ДЭВШИЛ МАНДАЛ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Дэвшил мандал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 09.00-12.00 цагийн хооронд Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бага тойруу Монбармат ХХК-н конторын 306 тоот өрөөнд зохион байгуулагдлаа.

Тооллогын комиссоос, саналын эрхтэй 70420 ширхэг хувьцааны 85.64 % буюу 60309 ширхэг хувьцааг эзэмшигч 4 иргэн өөрийн биеэр оролцож байгаа тул хурлын ирц хүчин хангалттай төгөлдөр гэж үзэж байгаагаа танилцууллаа.

Хурлын тооллогын комиссын дарга Г.Даваажамц: Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хуулийн дагуу хийж, ирцыг мэдээлж, санал өгөх зааврыг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчид нь хурлаар хэлэлцэх асуудалд саналыг өгөхдөө батлагдсан саналын хуудасуудыг ашиглан бичгээр өгнө. Харин Төлөөлөн удирдах Зөвлөлийн гишүүнийг сонгох саналыг "Санал хураах кумулятив арга хэрэглэх журам"-ыг баримтлан санал өгнө гэж тодорхой тайлбарлан танилцууллаа.

Хурлын дарга: Д.Санжмятав: Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Монгол улсын Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2 удаа зарлаж, мөн Монголын хөрөнгийн биржийн цахим хаягт байршуулсан болно.

Хурал зохион байгуулах тооллогын комиссын даргын танилцуулснаар энэ удаагийн хурлын ирц хангалттай буюу 85.64%-тай байна. Иймээс, хурлаар хэлэлцэх асуудлуудаа цааш нь үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзээд хурлын дэгийг танилцуулж, өөр санал байгаа эсэхийг хуралд орлогчдоос дахин асууж тодруулахад нэмэлт санал байхгүй байлаа.

Иймээс, компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 01/02 дугаар тогтоолоор батлагдсан дараах асуудлуудаа хэлэлцье.

Хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийн тухай
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, түүнд Төлөөлөн удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлт, шийдвэрийг батлах
3. Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож батлах

5. Компанийн санхүү болон үйл ажиллагаанд тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэх талаар

6. Компанийн хэлбэрийг өөрчлөх талаарх асуудлыг хэлэлцэх

7./ Бусад.. Компанийн өр, зээл болон Компанийн хэлбэрийг өөрчилж, ХХК болгох асуудлыг хэлэлцэх. / зэрэг асуудлуудыг хэлэлцэж танилцуулья.

Үүнд:

- Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг

- Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, түүнд Төлөөлөн удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлт, шийдвэрийг батлахыг

- Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах... гэсэн дээрхи 3 асуудлуудыг хувьцаа эзэмшигч нар сонсож, зохих хариулт, ярилцлага хэлэлцүүлгүүдийг өрнүүлснээр санал нэгтэй хэлэлцэн батлав.

-Компанийн,Төлөөлөн удирдах зөвлөлийг нийт 9 гишүүдтэйгээр, үүнээс: ердийн гишүүн-6, хараат бус 3 гишүүнтэй байхаар нэр дэвшүүлэн санал хурааж шинэчлэн сонгов.

-“Дэвшил мандал” хувьцаат компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар авч хэлэлцээд, санхүү мөнгөний боломжгүйгээс бусдад өр төлбөр ихтэй, мөн тус компанийн 50 гаруй жилийн өмнө анх баригдсан барилга байгууламж нь эвдэрч гэмтэн актлагдсан ба цаашид шинэчлэн барьж, үйл ажиллагаа явуулах боломжгүйгээс байнгын зогсож байгаа тул “хангалтгүй” гэж дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнөх шийдвэрийг зөвшөөрч батлав.

-Компанийн хэлбэрийг өөрчлөх талаарх асуудлыг хэлэлцэх

-Бусад.../ Компанийн өр, зээл болон Компанийн хэлбэрийг өөрчилж, ХХК болгох асуудлыг хэлэлцэх.../ зэрэг нийт 2 асуудлыг доорхи байдлаар хэлэлцэж шийдвэрлэлээ. Үүнд :

Хувьцаа эзэмшигч Д.Санжмятав: Өнгөрсөн жилүүдэд үүссэн санхүүгийн хуримтлагдсан өр зээлийн асуудлуудыг шийдвэрлэх талаар доорхи саналыг дэвшүүлж байна. Үүнд :

Хувьцаа эзэмшигч нарыг хэлэлцэж байгаа дээрхи асуудлуудтай холбогдох ойлголтыг зөв аваасай гэж хүсэж байгаа тул дэлгэрэнгүй тайлбарлахыг хүсэж байна

Манай компанийн барилга нь одоогоос 53 жилийн өмнө буюу 1973-1974 онд Дундговь аймгийн төвд Барилгын материал үйлдвэрлэх зориулалтаар анх баригдаж ашиглалтад орсон барилга юм.

Монгол улсад зах зээл, өмч хувьчлал эхэлсэн 1990 оноос хойш өнөөдрийг хүртэл өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд санхүүгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан үйл ажиллагаа явуулах боломжгүйгээр хуучирч муудан зогсож байна.

Баригдаад 53 жил болсон манай компанийн тус барилгын ашиглалтын хугацаа дууссан, барилгын суурь, хана, дээврийн хэсэгт нэвт хагарал цуурлууд үүсэж эвдэрсэн ба улмаар улсын байцаагчийн “цаашид ашиглах боломжгүй... зогсоосон” гэсэн акт, албан шаардлага, дүгнэлтүүд удаа дараа гарсан болно.

Мөн, орон нутгийн засаг захиргааны холбогдох байгууллагуудаас ч гэсэн буулгах тогтоол шийдвэрүүд гарсан болно.

Дэвшил мандал ХК-г., ХХК /Хязгаарлагдмал хариуцлагатай компани/ болгож, хувьцаа эзэмшигч бүрийн эзэмшиж байгаа хувьцааны тоо болон үнэлгээ-г тооцоолон гаргуулж холбогдох үнэлгээний дүнг МХБирж, ҮЦТХХТөв-д төвлөрүүлэх саналтай байна.

Компанийн хуримтлагдсан өр зээлийн асуудлуудыг шийдвэрлэх, хувьцаа эзэмшигчдийг хохироохгүйн тулд ХК-н хэлбэрийг ХХК болгон өөрчлөх дараах саналыг дэвшүүлж, зарим бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгээд байгаагаа мэдэгдэж байна. Үүнд :

1. Дэвшил мандал ХК-ийн 2025 оны санхүү татварын тайланд, Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй "Лидер Экуант Аудит" ХХК-иар хараат бус аудитын тайланг хийлгэж бэлэн болгоод байна.

2. Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй "Тэнгэрийн гэрэл үнэлгээ" ХХК-иар "Дэвшил мандал" ХК-ийн хөрөнгөнд "Хөрөнгийн үнэлгээ" болон "Бизнес үнэлгээ" хийлгэж холбогдох тайлангуудыг бэлэн болгоод байна.

Хувьцаа эзэмшигч Я.Өлзий-Утас : Үйл ажиллагаа явуулах боломжгүй учраас тус компанид банк санхүүгийн байгууллагууд зээл өгөх боломжгүй болсон, одоогоор өр зээл, татвар зэрэг мөнгөн зарлагуудыг зөвхөн таньдаг хувь хүмүүсээс хүү өндөртэйгээр зээлж байгаа шүү дээ. Цаашид тавьсан өр зээлээ төлөхгүй бол шүүхэд очих нь дээ. Компанийн хэлбэрийг өөрчилж, ХХК болгох боломжтой гэж үзэж дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч С.Амармандах : Жил бүр бүртгэлийн хураамжууд, цалин хөлс, татвар, нийгмийн даатгал төлөвлөгдөөгүй бусад жижиг зардлууд гэх мэт нь нэмэгдээд, зээлсэн өр зээлийн хүү-нүүд нэхэгдээд хэцүү байгаа тул ойрын үед шийдвэрлэх, гарц гаргах нь чухал байна. Компанийн хэлбэрийг өөрчилж, ХХК болгох боломжтой гэж үзэж байгаа бөгөөд, компанийн санхүү тайлан, хөрөнгө ... зэрэгт зохих үнэлгээг эрх бүхий холбогдох газруудаар хийлгэж хавсаргасан болно.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох дээрхи саналыг дэмжиж байна

Хувьцаа эзэмшигч С.Энхмандах : Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын гаргасан саналуудыг дэмжиж байна.

Өөр зүйлгүй гэснээр саналын асуудал түр дууслаа.

Та бүхний гаргасан саналыг хүлээж авлаа. Энэ талаар нарийн тооцоо судалгаа хийж, цаг алдалгүй үйл хэрэг болгохыг шинээр сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад үүрэг болгохоор тогтлоо.

Иймээс дээрх асуудлуудын талаар тооллогын комисс санал хураасан тооллогын комисс ажилдаа орж саналын хуудсыг тоолж дуусаад тооллогын комиссын дарга Г.Даваажамц тооллогын комиссын тогтоолуудыг, хурлын дарга Д.Санжмятав хурлаас гарсан шийдвэрүүдийг уншиж танилцууллаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт болон компанийн хөрөнгийн үнэлгээ зэргийг /хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар/ баталлаа.

2. Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар баталлаа.

3. Компанийн ТУЗ-ийн гишүүнээр дээрхи нэр бүхий гишүүдийг /хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн/ 100 хувийн саналаар сонгож батлав

4. Компанийн хувьцаа эзэмшигчдийг төлөөлж Төлөөлөн удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирлагуудаас компанийн хэлбэрийг өөрчлөн "Хувьцаат компанийг, Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани" болгох тухай саналыг болон хийгдэж буй дээрхи ажлуудыг хугацаа алдалгүй хурдан гүйцээн хийж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Хурлын тэмдэглэл
хөтөлсөн :



 С.АМАРМАНДАХ

Хурлын тэмдэглэлтэй танилцсан
Хурлын дарга :

 Д.САНЖМЯТАВ